ҮЕР, УСНЫ АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, БЭЛЭН БАЙДЛАА ХАНГАХ

ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ: ҮЕР, УСНЫ АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, БЭЛЭН БАЙДЛАА ХАНГАХ

СЭДВИЙН ЗОРИЛГО:

Иргэдэд үер, усны аюулын талаар ерөнхий ойлголт өгч, түүнээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлаа хангах арга ухаанд сургах

АГУУЛГА:

- Үерийн тухай ерөнхий ойлголт
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- Үерийн нөхцөл байдал, үүсэх шалтгаан
- Үерт өртсөн тохиолдолд авах арга хэмжээ
- Зөвлөмж

YEP

Богино хугацаанд эрчимшил ихтэй борооноос эсвэл харьцангуй аажуу үргэлжлэх хайлсан цас, мөсний улмаас усны түвшин эрс нэмэгдэн голын эргээс даван хальж, татам болон эрэг орчмын газар орон усанд автахыг хэлнэ.

ҮЕРИЙН ТӨРӨЛ

ШАР УСНЫ ҮЕР
/4-5 сард/

УРУЙН ҮЕР
/5-9 сард/

ХУР БОРООНЫ ҮЕР
/6-9 сард/

ХУР БОРООНЫ ҮЕР /6-9 сард/

*Эрчимшил ихтэй хур борооноос голын урсац, түвшин богино хугацаанд нэмэгдэн голын ус эрэг савнаасаа хальж давах үерийг **хур борооны үер** гэнэ.*

2009 оны 7 дугаар сарын 17-нд хүчтэй аадар бороо 1.5 цаг орчим орж нийслэлийн ихэнх дүүрэгт уруйн үер бууснаас Баянзүрх дүүрэг, Хан-Уул дүүргийн Зайсан, Биокомбинат орчимд 130 айл орон гэргүй болж, 25 хүн амь насаа алдан, 1 тэрбум 200.0 сая төгрөгийн хохирол учруулсан.

ШАР УСНЫ ҮЕР /4-5 сард/

Хайлсан цас, мөсний улмаас голын урсац, усны түвшин харьцангуй урт хугацаанд нэмэгдсээр голын ус эргээсээ хальж давахыг хэлнэ.

Халх голд 1999 оны 4 дүгээр сар

Халх голын усны түвшин 1999 оны 4 дүгээр сарын 09-13-ны хугацаанд бараг 200 см гаруйгаар огцом нэмэгдэж, Халх голын хөвөө, татамын бургасанд өвөлжиж байсан малчдын өвөлжөө, гэр орон усанд автаж, 2 айлын 22 хүн усанд боогдсон үед нисдэг тэргээр нүүлгэн шилжүүлсэн байна. Энэхүү шар усны үерт 2 айлын гэр, 60 гаруй мал урссан байдаг.

УРУЙН ҮЕР /5-9 сард/

Богино хугацаанд орсон эрчимшил, ихтэй аадар борооны улмаас хэвгий ихтэй жижиг гол, сайруудаар үерийн ус хурдтайгаар буухыг ***уруйн үер*** *гэх бөгөөд зарим орон нутагт* ***"ЗЭРЛЭГ ҮЕР"*** *хэмээн нэрлэдэг.*

2003 оны 7 дугаар сарын 18-нд Улаанбаатарт хот орчимд хүчтэй аадар бороо, мөндөр 20-22 минут үргэлжилж, 28-54 мм тунадас (энэ нь 7 сарын нийлбэр тунадасны 40-50 хувь болох) унасны улмаас үер болж 10 хүний амь нас эрсдэж, 130 км үерийн далан, суваг эвдэрч, 300 айл усанд автаж, 93 айл урсаж, 1360 ам метр авто зам эвдэрч, нийт 300 сая төгрөгийн хохирол учиржээ.

Энэ уруйн үерийн урсгалын хурд 1.5-2.0 м/сек хүрч, сайраар буусан үерийн өнгөрөлт 8.0-17.5 $м^3$/сек байжээ.

ШАЛТГААН

Уур амьсгалын өөрчлөлт, голын сав газрын байгалийн нөхцлийн өөрчлөлт (хөрс, бэлчээр талхлагдсан, ой, ургамлын бүрхэвч ядуурсан) зэрэг шалтгаанаар гадаргын шууд урсацын хэмжээ нэмэгдэж, шар усны болон хур борооны үерийн хэмжээ ихсэж **ҮЕРИЙН АЮУЛТАЙ** нөхцөл нэмэгддэг.

ШАЛТГААН

Үерийн ус зайлуулах далан суваг, нүхэн гарц, хоолойг бөглөх, өөрчлөх, хаах болон үерийн аюултай бүс нутаг болох голын голдирол, уулын ус урсдаг сайр, намагт барилга, гэр, хашаа барих, зам тавих зэргээс үүдэлтэй **“ЗОХИОМОЛ ҮЕР”** үүсэх нөхцөл бий болдог.

УЛСЫН ХЭМЖЭЭНД ТОХИОЛДСОН ААДАР БОРОО, ҮЕРИЙН ТОО



Жилд дундажаар 30 удаа аадар бороо, үер тохиолдож байна.

ҮЕРИЙН АЮУЛЫН ХУВЬД “УРСАХ ХУГАЦАА” – Г ТООЦООЛОХ НЬ ЧУХАЛ

Энэ нь үер үүсгэхүйц хур бороо орсоноос хойш голын аль нэг чиглэлд, эсвэл усны харуулд, эсвэл ямар нэгэн хот, сууринд үер орж ирэх хүртэлх хугацааг хэлнэ.

Хур бороо намдсаны дараа үерийн аюул тохиолдохгүй гэж ойлгож болохгүй.

Улаанбаатар хотод түүхэндээ 3 том үер тохиолдсон. /1962 он, 1966 он, 1982 он/
1966 оны 7-р сарын 10-12 нд болсон үер

Улиастай голын гүүрээр гарч явсан автобус усанд унаж, 100 гаруй зорчигч амь насаа алдсан.

Үерт өртсөн 13.000 айл өрхийг 17 хэсэгт нүүлгэн шилжүүлж, маахуур толгойн усан сан үерт автаснаас цэвэр усны хомсдолд орсон тул Зүүнхараа хотоос төмөр замаар хоногт 9.5 вагон цистернээр цэвэр ус зөөвөрлөж, иргэдийг усаар хангаж байжээ.

Үерийн дараах сэргээн босгох ажилд улсын төсвөөс хөрөнгө гаргаж, зам, гүүр, далан суваг, барилга байгууламжийг сэргээхэд нийтдээ 300 сая төгрөгийн хохирол, зардал гарсан гэж тэмдэглэжээ.

(1990 он СНЗ-ийн архив, 1990). /



Баян-Өлгий аймагт 2016 оны 7-р сарын 10-нд аадар бороо орж, Өлгий хот бүхэлдээ үерийн усанд автсаны улмаас Ховд голын эргээр оршин суудаг 160 гаруй өрх үерт нэрвэгдсэн. Үерийн улмаас 640 гаруй иргэн орон гэргүй болжээ.

Өлгий суманд хүчтэй аадар борооны дараа 30 минут мөндөр үргэлжлэн орсон байна.

ҮЕРИЙН ХОР УРШИГ

Үерээс үүдэн

-Хөрсний гулсалт үүсэх

- Цахилгаанаас үүдэлтэй гал гарах

- Хөрс, усны бохирдол үүсэх

- Барилга байгууламж, гэр сууц усанд автах
- Иргэд амь насаа алдах
- Халдварт өвчин тархах
- Тариалангийн талбай үерт автах

ҮЕРИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

ҮЕРИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Сэрэмжлүүлэг, мэдээ тогтмол хүлээн авах

Гэр, хашаа, саравч, орон байрыг барих газраа үнэлэх



Уламжлалт аргад суралцах

Даатгалд хамрагдах

Чухал бичиг баримтаа хадгалах

Нөөцөө бүрдүүлэх

Үерийн аюултай бүс нутгаас нүүх

Далан, суваг, шуудуу, хашлага барих

Хүүхдийг хараа хяналтгүйгээр гол мөрөн, нуур, цөөрмийн орчимд тоглуулахгүй, орхихгүй байх

ҮЕРТЭЙ БАЙНА ГЭЖ ҮЗСЭН ТОХИОЛДОЛД...

ХҮЛЭЭ
УС БҮҮ ГАТАЛ

ӨНДӨРЛӨГ ГАЗАРТ ОЧ

НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ҮНЭЛ

Үерийн аюул тохиолдоход амь насаа хамгаалах нь чухал

- Байшингийн дээвэр, ургаа мод зэрэг аль ойрхон өндөрлөг газар гарах

- Үер бууж болзошгүй хавцал, хонхор, нам дор газраас хол байж аль ойр байгаа өндөрлөг гарч тэндээ хүлээх

- Гол мөрөн үертэй үед усанд орох, гол гатлах, загасчлах, усны эрэг орчмоос хол байх

- Усархаг, үргэлжилсэн хүйтэн бороотой үед болон аадар бороо, мөндөр орж байхад мал хариулах, эрэлд явах, мал услах, мал туухгүй байх

- Аялал зугаалга, аян замд гарахыг хойшлуулах

ҮЕРИЙН АЮУЛЫН ДАРААА ТА ЮУГ АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАЖ БУСДАД ТУСЛАХ

- Өөртөө болон бусдад туслах
- Эвдэрч нурсан газраас холдож аюулгүй газар очих
- Барилга байгууламжийн гадуур устай байвал дотогш оролгүй хүлээх

ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ

- Ундны усыг заавал буцалгаж хэрэглэх
- Норсон хүнсний бүтээгдэхүүнийг устгах
- Гараа тогтмол савандаж угаах
- 00, муу усны нүх /сав/-ийг ариутгах, цэвэрлэх

МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГАД ХАНДАХ

- Эмнэлгийн байгууллагад хандах
- Эвдрэл гэмтэлтэй холбоотой мэргэжлийн байгууллагад хандах
- Хохиролоо барагдуулахтай холбоотой даатгалын байгууллагад хандах

УСАНД ОСОЛДОЖ АМЬ НАСАА АЛДСАН ХҮМҮҮСИЙН ДИЙЛЭНХ НЬ УСАНД СЭЛЖ ЧАДДАГ ХҮМҮҮС БАЙХ ТОХИОЛДОЛ БАЙДАГ

Дэлхийн хэмжээнд живэлт нь хүүхдийн нас баралтын тэргүүлэх шалтгаануудын нэг болдог.

Дэлхийн хэмжээнд жилд дунджаар 500,000 хүн усанд осолдож амь нас алддаг байна.

Монгол улсын хэмжээнд усанд осолдсон золгүй тохиолдлын тоо



Жилд дундажаар 95 удаагийн золгүй тохиолдол гарсан байна.

Монгол улсын хэмжээнд үер, усны ослоор амь насаа алдсан хүүхдийн тоо



Жилд дундажаар 20 удаагийн золгүй тохиолдол гарсан байна.

Живж байгаа хүнийг аврах арга хэмжээ

ямар нэгэн юм
СУНГА ямар нэгэн юм ШИД

- ✓Живж байгаа хүнийг аврах хамгийн аюулгүй арга замыг сонго
- ✓Ус руу өөрөө орж болохгүй
- ✓Хуурай эргээс гараа сунга, саваа мод, модны мөчир, уяа, аврах хөвөгч зэрэг аль боломжтой байгаа зүйлийг сунга, шидэж өг.

Усанд осолдсон, живсэн хүнд яаралтай авах арга хэмжээ

Өөртөө аюулгүйгээр хуурай газарт гаргах

Анхны тусламж үзүүлж, дулаан байлгах

Эмнэлэгт яаралтай хүргэх

World Vision
Дэлхийн Зөн Монгол

Анхаарал хандуулсанд баярлалаа

ANHAAR APP

- Гамшиг, ослын үед авах арга хэмжээ
- Холбоо барих байгууллагууд болон утасны дугаарууд
- Амилуулах суурь тусламжийн зааврууд
- Гамшиг, ослын үед ашиглах хэрэгслүүд

Available on the App Store
ANDROID APP ON Google play

www.ontsgoisur.gov.mn